

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### RISK ANALYSIS OF POLICE ORGANIZATIONAL ACTIVITIES

#### Бямбаноровын Нямдаваа\*

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн хошууч

**Pol. Maj. Nyamdavaa Byambanorov**, MA scholar, University of Internal Affairs

#### Эрдэнэбатын Энхболд

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн хошууч

**Pol. Maj. Enkhbold Erdenebat**, MA scholar, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: nmdv0625@gmail.com

**Хураангуй:** Байгууллагын удирдлагын үндсэн үүрэг бол эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явдал ба үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж чадаагүйн улмаас байгууллага зорилгодоо хүрч чадахгүй байх, үйл ажиллагаа саатах, ихээхэн хэмжээний хохирол амсах, алба хаагч, ажиллагсдын эрх ашиг, эрүүл мэнд зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаврууд үүсэх шалтгаан болно.

Тус өгүүлээр цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээний тайлан болон төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагуудын эрсдэлийн судалгаанд дүн шинжилгээ хийж алба хаагчийн аюулгүй байдалд эрсдэл учрах, эрүүл мэндээр хохирох, төсөв санхүүгийн хомсдол үүсэх зэрэг өндөр үнэлгээтэй 3 төрлийн эрсдэлийг сонгож дэлгэрүүлэн судаллаа.

Мөн Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны эрсдэлийн судалгааг хийж эрсдэлийг тодорхойлох, олон улсад ашиглагддаг COSO (Committee Of Sponsoring Organizations) аргачлалаар матриц үүсгэн үйл ажиллагааны эрсдэлийг шинжилж цаашид сайжруулах арга зам, дүгнэлт, санал боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, өндөр эрсдэлийг тогтоох, тэдгээрийг арилгах чиглэлээр сайн туршлагыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр санал дэвшүүлэхийг зорилоо.

**Abstract:** The main role of the organization's management is to implement risk management, which is an important component of operations. Failure to implement risk management effectively can lead to negative consequences, such as not achieving goals, delays in operations, significant losses, and violations of the rights and health of officers and employees.

This article analyzes the risk assessment report of the Police Organization, as well as risk studies conducted by non-governmental organizations and research institutions. It focuses on three types of high-rated risks: risks to officer safety, health hazards, and budgetary and financial shortages.

Furthermore, a study was conducted to identify risks in the activities of Police Officers. A matrix was created using the internationally recognized COSO (Committee of Sponsoring Organizations) methodology to analyze operational risks and develop recommendations for further improvement.



Additionally, this analysis aims to examine the implementation of risk management in the Mongolian Police and propose strategies for incorporating best practices in identifying and mitigating high risks.

**Түлхүүр үгс:** Цагдаагийн байгууллага, байгууллагын эрсдэл, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн үнэлгээ.

**Keywords:** Police organization, Organizational risk, Risk management, Risk assessment.

### Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж хуульчилсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн” (Цагдаагийн албаны тухай хууль, 2017) нарийвчлан тус байгууллагын чиг үүргийг хуульчилсан.

Цагдаагийн байгууллага нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, байгууллага, алба хаагчийнхаа аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байнга үүсэж байдаг.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх хэсэгт Цагдаагийн ерөнхий газрын дарга нь “цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж тусгаад, хуулийн хэрэгжилтүүдийг хангах чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн

бодлогын баримт бичгийн 7 дугаар зорилтын 7.3 дахь хэсэгт “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ”, мөн 7.3.16 дахь хэсэгт “Аюулын төрөл бүрээр гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал, загварчлал боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийнэ.” (“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020) гэж заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор батлуулсан Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.3.1 дэх хэсэгт “цагдаагийн төлөвлөлтийн чиг үүргийн хүрээнд стратегийн, хөтөлбөрийн, шийдвэр гаргалтын, инновацын, төслийн, маркетингийн, өөрчлөлтийн, харилцааны, эрсдэлийн, цагийн удирдлагын аргуудыг нэвтрүүлэх”, мөн 3.2.5.3 дахь хэсэгт “цагдаагийн байгууллагын гүйцэтгэлийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах” (Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, 2020) гэсэн заалтуудыг тусгуулж хэрэгжилтийг хангах чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Хууль, дүрэм, журам бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагаас 2014-2024 онд нийт 14 удаа эрсдэлээ тодорхойлж үнэлгээ хийн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-





шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлжээ.

Цагдаагийн байгууллага сүүлийн жилүүдэд эрсдэлийн талаарх судалгаа шинжилгээ, эрх зүйн зохицуулалтуудыг нэлээдгүй хийсэн. Гэвч эрсдэлээс бүрэн урьдчилан сэргийлж чадахгүй, бодит үр дүнд хүрээгүй, энэ талаар эрдэм шинжилгээ судалгааны ажлууд хомс байна.

Түүнчлэн Цагдаагийн байгууллага нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд дараах төрлийн эрсдэлүүд өндөр байгаа нь бусад судалгааны дүнгүүдээс харагдаж байна. Тухайлбал,

Залуу судлаачдыг дэмжих сан төрийн бус байгууллагаас 2023 онд Цагдаагийн албаны үйл ажиллагаа дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаагаар “цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагч нь Монгол Улсын 119 хуулийн 1637 заалт, 285 дүрэм, журмын хүрээнд 6700 гаруй үүрэг хүлээдэг, тэдгээрийн 40 орчим хувь нь доголдолтой, уялдаа холбоогүйн улмаас тус байгууллагын ажлын ачаалал жилээс жилд нэмэгдэж иргэдэд хүрэх үйлчилгээний чанарт нөлөөлж ирсэн.

Мөн байгууллагын бүтэц, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцөд хомсдол үүсэж функцийг гүйцэтгэлийн хувьд гацах, үр дүн, бүтээмжийн зогсонги байдалд хүрэх эрсдэл бий болсон тул дунд хугацаандаа хөндлөнгийн мэргэжлийн байгууллагатай хамтран бүтцийн шинэчлэл, өөрчлөлт хийх, урт хугацаанд зохиомол ачааллыг багасгаж, үр өгөөжтэй бүтцийг бий болгох, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, цалин хөлсийг бусад ижил чиг үүргийн байгууллагатай уялдуулан нэмэх шаардлагатай (Залуу судлаачдыг дэмжих сан төрийн бус байгууллага, 2023) гэж дүгнэсэн судалгаа гарчээ.

Түүнчлэн Максима судалгааны төвөөс 2022 онд Цагдаагийн ажиллах

нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа хийхэд ажилтан, алба хаагчдын 91.2 хувь нь банкны зээлтэй, өдөр тутам ажлын цаг 30 хувийн хэтрэлттэй, тухайлбал, бүх нийтийн баяр, амралтын өдрүүдийн талаас илүү хувьд нь бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилладаг, нийт бүрэлдэхүүний 61.9 хувь (27.5 хувь нь цусны даралт, 10.7 хувь нь бөөр, 6.1 хувь нь ходоод, 6.3 хувь нь чихрийн шижин, 5.0 хувь элэгний вирусийн гаралтай үрэвсэл, хатуурал, 5.5 хувь нь нурууны эмгэг) өвчлөлтэй, нас баралтын эрсдэл их байгааг онцолсон (Максима судалгааны төв, ЦЕГ, 2022).

Энэ чиглэлээр цагдаагийн байгууллагаас хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2023, 2024 онуудад алба хаагчдын цалингийн шатлалыг 2 удаа шинэчлэн нэмэгдүүлж, үйл ажиллагаандаа дахин процессын инженерчлэл хийх ажлыг 2024 онд эхлүүлсэн байна.

Дээрх судалгаануудаас үзэхэд цагдаагийн байгууллага нь эрсдэлээ үнэн бодит байдлаар тодорхойлж, хариу менежментийн төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх, мэдлэг, чадварыг эзэмших хэрэгцээ, шаардлага удирдлагад тулгарч байна.

Эдгээр судалгаануудаас харахад үндсэн 3 эрсдэлийг гаргаж хөнджээ. Үүнд:

1. Алба хаагчийн аюулгүй байдал.
2. Эрүүл мэнд
3. Нийгмийн баталгаа ялангуяа

цалин хөлс хэрэгцээг хангахгүй байх эрсдэлүүд өндөр үзүүлэлтэй байна.

Иймд цагдаагийн байгууллага нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд тулгарч буй эрсдэлийн удирдлагын тогтолцоог онол, арга зүйн үндэслэлтэй үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, эрүүл мэнд, цалин хөлс нийгмийн баталгаа хангагдаж, эрсдэл,

аюул, ослоос урьдчилан сэргийлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдах зэрэг олон талын эерэг ач холбогдолтой тул энэхүү сэдвээр судалгааны ажил явуулахаар сонгосон болно.

### Үндсэн хэсэг

Цагдаагийн байгууллага нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж чадаагүйн улмаас зорилгодоо хүрч чадахгүй байх, үйл ажиллагаа саатах, ихээхэн хэмжээний хохирол амсах, алба хаагч, ажиллагсдын эрх ашиг, эрүүл мэнд зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаврууд үүсэх шалтгаан болно. Иймд эрсдэлийг тогтмол тооцоолж удирдах шаардлагатай.

Эрсдэлийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө

эрсдэлүүдийг ач холбогдлын зэргийн түвшнээс хамааруулж Их, Дунд, Бага гэж зэрэглэн эрсдэлийн матриц үүсгэж удирдах арга хэмжээг тодорхойлно.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021, 2022 онд нийт 3299 төрлийн эрсдэлийг олон улсын COSO (Committee Of Sponsoring Organizations) аргачлалаар тодорхойлсноос 2022 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд “Ач холбогдлын зэрэг”-ээр “Их” буюу “Эрсдэлийн тоон түвшин”-ээр 20-25 оноогоор үнэлэгдсэн нийт 40 төрлийн эрсдэлийг сонгон авч статистик дүнг чанарын судалгаатай харьцуулан анализ хийхэд 20 оноогоор үнэлэгдсэн 14, 25 оноогоор үнэлэгдсэн 26 эрсдэлт нөхцөл байдал бүртгэгдсэн байна (Цагдаагийн ерөнхий газар, 2022). Үүнд:

		Шийдвэрлэх арга хэмжээний санал	
		Байгууллагын дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч шийдвэрлэх боломжтой	ХЗДХЯ, дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх боломжтой
Эрсдэлийн түвшин	20	Б1, Б4, Б9, Б12, Б13, Б14, Б23, Б27, В2, Г4 /Бүгд-10/	А1, Б8, В3, Г3 /Бүгд-4/
	25	А2, Б5, Б10, Б11, Б21, Б22, Б24, В5, Г1, Г2 /Бүгд-10/	Б2, Б3, Б6, Б7, Б15, Б16, Б17, Б18, Б19, Б20, Б25, Б26, Б28, Б29, В1, В4 /Бүгд-16/
НИЙТ		20	20

Хүснэгт 1. Их эрсдэлтэй үйл ажиллагааг шийдвэрлэх матриц санал

Цагдаагийн байгууллага нь 2021 онд өндөр үнэлгээтэй нийт 14 төрлийн эрсдэл, 2022 онд өндөр үнэлгээтэй нийт 26 төрлийн эрсдэлийг байгууллагын хэмжээнд болон Хууль зүй, дотоод

хэргийн яаманд уламжлан шийдвэрлүүлсэн байна.

Эдгээр 40 эрсдэлээс алба хаагчийн аюулгүй байдал, эрүүл мэнд, төсөв санхүүтэй холбоотой аюулын зэрэг өндөр 25 эрсдэл бүртгэгдсэн байна. Тухайлбал,

д/д	Эрсдэлийг бүртгэх хүснэгт		
	Эрсдэл төлөлийн	Тодорхойлсон эрсдэл	Эрсдэлийн үнэлгээ
			Эрсдэлийн нөлөө





ᠬᠤᠠᠭᠠᠳᠤᠬᠢᠭᠢᠨ ᠠᠯᠤᠰᠤ ᠬᠡᠭᠡᠨ ᠠᠶᠤᠯᠦᠭᠡᠢ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯᠤᠯᠠᠭᠤ

			Маш ховор тохиолдох	Тохиолдох боломж бага	Заримдаа тохиолдох	Бүрэн боломжтой	Байнга тохиолдох	Маш ховор тохиолдох	Тохиолдох боломж бага	Заримдаа тохиолдох	Бүрэн боломжтой	Байнга тохиолдох	Эрсдэлийн дүн
			1	2	3	4	5	1	2	3	4	5	
1	B1	Байгууллагын барилга байгууламж нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн шаардлага хангахгүй, багтаамж хүрэлцэхгүй байх /Нийт 23 байгууллага/					+				+		20
2	B1	Цагдаагийн алба хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад иргэдийн зүгээс үйл ажиллагаатай нь холбоотойгоор цахим сүлжээнд шууд бичлэг /лайв/ хийж, алба хаагчийг гүтгэх, доромжлох, биед халдах болон албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх					+					+	25
3	B2	Алба хаагчдын цалин мөнгө хүрэлцээгүйн улмаас авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох.					+					+	25

Хүснэгт 2. Эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Нэгжийн хэмжээнд авч үзвэл: алба хаагчийн аюулгүй байдалтай Нийтийн хэв журам хамгаалах, олон холбоотой 18 төрлийн эрсдэлийн тооцож, нийтийн аюулгүй байдлыг хангах хариу арга хэмжээний төлөвлөлт хийсэн чиглэлээр хариуцсан албанаас 2021,2022 байна. (Эрсдэлийн тайлан, 2022) онуудад хийсэн эрсдэлийн үнэлгээнд Тухайлбал,

№	Эрсдэлийн код	Тодорхойлсон эрсдэл	Эрсдэлийг бүртгэх хүснэгт												
			Эрсдэлийн үнэлгээ										Эрсдэлийн дүн		
			Эрсдэлийн нөлөө					Эрсдэл үүсэх магадлал							
			Маш ховор тохиолдох	Тохиолдох боломж бага	Заримдаа тохиолдох	Бүрэн боломжтой	Байнга тохиолдох	Маш ховор тохиолдох	Тохиолдох боломж бага	Заримдаа тохиолдох	Бүрэн боломжтой	Байнга тохиолдох			
1	2	3	4	5	1	2	3	4	5						
1	B.1	Алба хаагчдад нэг бүрийн агсамж, тусгай			3					1		3			9

		хэрэгсэл, тусгай зориулалтын хувцас хэрэгсэл, энгэрийн камерын хүрэлцээ хангалтгүй байгаа нь алба хаагч гэмт хэрэгт холбогдох, амь нас эрүүл мэндээрээ хохирох, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай дамжуулах, албаны хэвийн үйл ажиллагаа алдагдах										
2	Б.2	Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллагаанд оролцож байгаа алба хаагчдад богино долгионы станц, чихэвч хангалтгүй улмаас дарга удирдлагаас өгсөн үүргийг буруу сонгох, сонсохгүй байх шалтгааны улмаас өгөгдсөн команд дохиог буруу ойлгох, ажиллагаанд орох үед бэртэж, гэмтэх, цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн сум, хэрэглэлийн нөхөн хангалт, нөөц бүрдүүлэлт, хадгалалтын хугацаа зэрэгт анхаарах, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн сумны хадгалалтын хугацаа дууссаны улмаас нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч үйлчлэхгүй, утаа гарахгүй, сум задрахгүй байх алба хаагчид нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед халдлагад өртөх				5				5	25	

Хүснэгт 3. Эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Дээрх судалгааны дүнг нэгтгэхэд 2021, 2022 онуудад давхардсан тоогоор 3299 эрсдэлийн мэдээлэл бүртгэгдсэнээс 2022 онд 40 эрсдэлийг сонгон авч анализ

хийхэд алба хаагчийн аюулгүй байдалтай холбоотой өндөр эрсдэлтэй 26, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг





гүйцэтгэдэг алба хаагчид 18 төрлийн эрсдэл учирч болох талаар үнэлгээ хийгдсэн байна.

Иймээс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийг оновчтой тодорхойлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай гэж үзэхээр байна.

### Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдэд хангалттай тусгасан боловч бусад байгууллагаас гаргасан судалгаа, байгууллагын эрсдэлийн удирдлагын үнэлгээ зэргээс дүгнэхэд алба хаагчийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учрах эрсдэл өндөр үнэлгээтэй хэвээр байна.

Цагдаагийн байгууллагаас 2014-2024 онуудад нийт 14 удаа эрсдэлээ тодорхойлж үнэлгээ хийн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн боловч эрсдэлийг тодорхойлохдоо олон улсад ашиглагддаг COSO (Committee Of Sponsoring Organizations) аргачлалаар матриц үүсгэхээс өөр загвар, аргачлал ашиглан эрсдэлээ тодорхойлдоггүй.

Тухайн аргачлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Хууль сахиулах салбарын байгууллагууд ашиглаж байгаа нь эрсдэлийг бүрэн тал бүрээс нь тогтооход учир дутагдалтай байна.

Цагдаагийн байгууллагаас эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төв байгууллага дээр эрсдэл хариуцсан нэгжтэй боловч харьяа нэгжүүдийн хэмжээнд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд “Байгууллагын эрсдэлийн удирдлагыг тухайн байгууллагын дарга хэрэгжүүлэх бөгөөд эрсдэл хариуцсан ажилтан (төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан албан тушаалтан)-ыг ажлын байранд хавсран

гүйцэтгүүлэхээр томилж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод нь энэ талаар тусгасан байна” гэж заасан.

Ингэснээр эрсдэлийн чиглэлээр мэргэшээгүй албан тушаалтан учирч болох эрсдэлийг үнэн бодит байдлаар тодорхойлж чадахгүйн улмаас байгууллага, алба хаагчид учрах эрсдэл буурахгүй байна.

Түүнчлэн тодорхойлсон эрсдэлийг арилгах, бууруулах чиглэлээр үр дүнд хүрсэн бодит ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж чадахгүй байгаа зэргээс эрсдэлийн түвшин өндөр хэвээр байна.

### Санал

Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх код-133 журамд “Байгууллагын эрсдэлийн удирдлагыг тухайн байгууллагын дарга хэрэгжүүлэх бөгөөд эрсдэл хариуцсан ажилтан (төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан албан тушаалтан)-ыг ажлын байранд хавсран гүйцэтгүүлэхээр томилж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод нь энэ талаар тусгасан байна” гэж заасныг эрсдэл, аюулгүй байдал хариуцсан албан тушаалтан гэж өөрчилж, мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэн нэгж бүрд ажлуулах.

Цагдаагийн байгууллага нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн удирдлагын олон улсад мөрдөгддөг COSO (Committee Of Sponsoring Organizations) аргачлалаар хийж байгаа нь хангалтгүй бөгөөд эрсдэлийг тал бүрээс нь бүрэн судалж, “Firm”, “Эрсдэлийг хянах” зэрэг олон төрлийн арга аргачлалаар тодорхойлдог байх.

Алба хаагчийн аюулгүй байдал, эрүүл мэнд, төсөв санхүүгийн гэсэн эрсдэлүүд өндөр байгаад онцгой анхаарч, урьдчилан сэргийлэх, арилгах чиглэлээр хариу төлөвлөлт хийж, шинэ, санал, санаачилга дэвшүүлэн бодит үр дүнд хүрсэн ажил арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах.

**Ашигласан материал**

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №25 (Улсын их хурлын тогтоол №52 2020 оны 05 13). Эрх зүйн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn-ээс> Гаргасан

Залуу судлаачдыг дэмжих сан төрийн бус байгууллага. (2023). *Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаа*. Улаанбаатар: TUSS.

Максима судалгааны төв, ЦЕГ хамтарсан. (2022). *Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа*. Улаанбаатар : Максима судалгааны төв.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №12 (Улсын их хурал 1992).

Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №08. (Улсын их хурал 2017).

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №40 (Монгол Улсын Засгийн газрын тогтоол №141 2020 оны 04 12). <https://legalinfo.mn/mn/>: <https://legalinfo.mn/mn/-ээс> Гаргасан

Цагдаагийн ерөнхий газар. (2022). *Эрсдэлийн тайлан*. Улаанбаатар: Цагдаагийн байгууллагын цахим сайт (<https://police.gov.mn>).

Цагдаагийн ерөнхий газар. (2022). *Эрсдэлийн тайлан*. Улаанбаатар: НХЖХОНАБХАлба.

